

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН
ГАЗРЫН НЭГДҮГЭЭР ХЭЛТСИЙН 2019 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.12.16

Улаанбаатар хот

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр

1.1 Төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлээр:

-Хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэр, бодлогын болон захиргааны үйл ажиллагааны баримт бичгийн зүйл, заалтын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан ажлын талаар

Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн даргын 2019 оны 5а/1687 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-ын дагуу салбар жагсаалтыг гаргаж, биелэлт үр дүнг тооцох нэгж, албан тушаалтныг томилон баталгаажуулсан.

Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны Удирдлагын газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 5/46 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, ажлын чиглэлийн талаар сургалт, мэдээлэл зохион байгуулж, хариуцсан албан тушаалтнуудад хүргүүлсэн.

Нийслэлийн цагдаагийн газраас 2019 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэх, хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх баримт бичгийн жагсаалтын дагуу хэлтсийн 2019 оны баримт бичгийн жагсаалтыг 2019 оны 08 дугаар сард 3 удаа шинэчлэн баталж, хариуцах нэгж, албан тушаалтнуудад хүргүүлсэн. Мөн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газраас ирүүлсэн төлөвлөгөөг тасгуудад хүргүүлж, биелэлтийг тооцсон.

Баримт бичгийн жагсаалтын дагуу 118 биелэлт тооцохоос 2019 оны гуравдугаар улирлын байдлаар бодлогын баримт бичиг 2, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн баримт бичиг 1, захиргааны байгууллагын үйл ажиллагааны баримт бичиг 1, шийдвэрийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бусад 12, нийт 56 баримт бичгийн биелэлт, үр дүнг нэгтгэн тооцож, тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлсэн.

Мөн “Хууль зүй дотоод хэргийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх 2019 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, “Зөв хэвшил, хандлага” аяны хүрээнд хийсэн ажлын явцын биелэлт, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, “Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтүүдийг хугацаанд нь гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн.

-Байгууллагын даргын зөвлөлийн хуралдааны талаарх мэдээлэл, тушаалын тоо, шийдвэрлэсэн асуудлын талаар:

Тайлант хугацаанд цагдаагийн хэлтсийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг 11 удаа хуралдаж, үйл ажиллагааны чиглэлээр 7, хүний нөөцийн чиглэлээр 30, алба хаагчдын сахилга хариуцлагын талаар 15, нийт 52 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, удирдлага, зохион байгуулалт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын чиглэлээр “А” тушаал 24, захиргаа, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр “Б” тушаал 25, нийт 49 тушаал гаргаж хэрэгжилтийг хангасан.

-Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгавар, ажлын чиглэл, зааварчлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажлын үр дүнг тодорхойлж, товч тайлагнах.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд, Дэд даргын баталсан 10 төлөвлөгөө, 7 хөтөлбөр, 8 ажлын үүрэг, чиглэл, Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн

цагдаагийн газрын даргын 10 үүрэг, 12 ажлын чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, 2019 оны байдлаар биелэлт, үр дүнг тооцож, холбогдох алба, нэгжүүдэд тогтоосон хугацаанд тайлагнасан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгаварын биелэлт, Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцож, холбогдох алба, нэгжид хүргүүлсэн.

-Дээд шатны байгууллагаас ирүүлж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, санамж бичиг болон бусад эрх зүйн актад хүргүүлсэн санал, шинээр батлагдсан эрх зүйн актуудыг дагаж мөрдөх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар

Тайлангийн хугацаанд дээд шатны байгууллагаас ирүүлж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, санамж бичиг болон бусад эрх зүйн актын 32 төсөлд санал хүргүүлсэн. Тухайлбал:

а. “Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулгын үйл ажиллагаа зохион байгуулах журам”-ын шинэчлэн найруулгын төсөлд 6 санал,

б. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2019-2020 оны бүсийн болон агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын төсөлд 3 санал,

в. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яамны Тэргүүн дэд сайд Ван Шио Хун манай улсад айлчлал хийхтэй холбогдуулан уулзалт, яриа хэлэлцээний сэдэвт тусгуулах 2 санал,

г. “Сайжруулсан түлшээр хангахад тулгарч буй хүндрэл бэрхшээл”-ийн талаар 2 санал,

д. “Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн этгээдэд урамшуулал олгох журам”-ын төсөлд 1 санал,

е. “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд 3 санал тус тус хүргүүлсэн.

ё. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Сахилгын шийтгэл оногдуулах /код 914/”-ын нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд 1 санал,

-Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, холбоо мэдээллийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаар товч тайлагнах

а.Архив, албан хэрэг хөтлөлт

Ажлын хэсэг архивт хадгалагдаж байгаа хадгаламжийн нэгжийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, архивын ажилтны ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 605,000 төгрөгний үнэ бүхий 3 ширхэг төмөр тавиур худалдан авч, дотоод нөөц бололцоог ашиглан архивын өрөөг засаж тохижуулсан.

Хэлтсийн архивт хадгалагдаж буй 2015-2017 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл болон устгах хэргийн актыг Цагдаагийн Ерөнхий Газрын БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Мөн 2018 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах хэргийн актыг үйлдэн 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 25и/4792 дугаартай албан бичгээр Төв архивт хүргүүлсэн.

2015-2018 оны цаасан суурьтай байнга хадгалах Захирамжлалын 30 боть 3909 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, 2007-2018 оны 2680 боть баримтаас 1994-2018 оны 70 жил хадгалах 123 боть 27396 хуудас, 2016-2018 оны байнга хадгалах 160 боть 22780 хуудас, түр хадгалах 2397 боть 572691 хуудас, нийт 622867 хуудас баримтыг бүртгэлжүүлэн тоолсон.

Баримтуудыг цэгцэлж, дахин шинээр зөв байрлал, дараалалд оруулж тавиурт байрлуулан он цагийн заагуур хийж архивын баримтуудыг нягтлан шалгаж сэлбэн засах шаардлагатай 1994-2003 оны 73 боть санхүүгийн баримтаас цалингийн картыг ялган 19 боть цалингийн картыг сэлбэн зассан.

Байгууллагын архивт хадгалагдаж байгаа баримт бүрийг нягтлан шалгаж, хадгалах хугацаагаар ангилан /байнга, түр, 70 жил, устгах/ төрөлжүүлж, данс бүртгэл үйлдсэн. Мөн хадгалагдаж байгаа баримтын 95 хувийг хамгаалалтын хайрцагтай болгосон.

Архивын ерөнхий газраас гаргасан маягтын дагуу архивын баримтын ашиглалтын бүртгэлийг хөтөлж, баримт ашиглалтын хуудсыг бөглөж хэвшсэн.

Байгууллагын баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу боловсруулж, захирамжлал болон зохион байгуулалтын баримт бичгийн хавсралтыг хавсарган үүсэн баримтыг цахим болон цаасан хэлбэрээр хэрэг бүрдүүлэн хадгалж ажилласан.

б.Холбоо, мэдээллийн чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээллийн технологи холбооны төвийн холбооны хэлтэс, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын холбоо, мэдээллийн инженертэй хамтран тус хэлтсийн хэт богино долгионы дахин дамжуулах радио станцыг Эрдэнэтолгой уулан дээр байрлах холбооны цамхаг дээрээс 2 ширхэг антенны хамт буулган авч БЗД 5 дугаар хороо Ромео Жульетта хотхоны дээвэр дээр байршуулан хөдөлгөөнт эргүүлийн автомашин болон жижүүрийн шуурхай албаны радио станцын ашиглалтыг сайжруулж, дахин дамжуулах суваг дээр хамгаалалтын тохиргоог хийж, хэвийн үйл ажиллагаанд оруулж ажилласан.

Хөдөлгөөнт эргүүлийн 5 автомашины хэт богино долгионы радио станц болон тусгай гэрэл, дуут дохионы хэвийн байдлыг ханган ажилласан.

Нийт давхардсан тоогоор 53 алба хаагчийн компьютерыг форматлаж, хэрэглээний програм хангамж суулган, цагдаагийн байгууллагын домайн сүлжээнд холбож, хэрэглэгчийн эрхээр нь нэвтрүүлэн цагдаагийн байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа Microsoft Lync, Outlook програм хангамжуудын тохиргоог хийж, принтерийг таниулан, шаардлагатай тохиолдолд нэмэлт тохиргоо болон програм хангамжийг суулгаж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Хэлтсийн 1, 2 дугаар байр, хариуцсан хороодын хэсгийн байцаагч нарыг цагдаагийн нэгдсэн сүлжээнд холбох, хэвийн ажиллагааг хангах хэвийн үйл ажиллагааг хамтран ажиллаж байна.

”Объект, субъектын цахим зураглал”-тай болох ажлын хүрээнд хороо хариуцсан хэсгийн байцаагч болон хороон цагдаа, эрүүгийн мөрдөгч нарыг мэдээлэл шивэхэд заавар зөвлөгөө өгч, өмнө нь шивэгдсэн байсан 713 мэдээллийг шинээр хийгдсэн програм хангамжид шивж оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хууль зүйн сайдын багцаас тус дүүргийн 4,5,14 дүгээр хороодод телехяналтын камерын ажил хийж байгаатай холбогдуулан гүйцэтгэгч компани болох ITFC компаний ажилчдад дэмжлэг үзүүлж ажилласан.

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн болон нэмэлтээр эмзэг цэг арга хэмжээний хүрээнд ажиллаж байгаа алба хаагчдын камерын бичлэгийг 120 удаа хуулбарлан авч алба хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангасан.

Нийт 265 аж ахуйн нэгж, иргэнд хяналтын камер нь MNS 6423:2019 “Телехяналтын системийн техникийн ерөнхий шаардлага”стандарт хангаж байгаа эсэх талаар тухайн байгууллагын камерын системд үзлэг хийж техникийн тодорхойлолт гарган үйлчилсэн.

-Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл, боломжийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар

Энэ онд бие бүрэлдэхүүний дундын сангаас алба хаагчдын нийгмийн асуудал, соён гэгээрүүлэх ажилд нийт 10,844,000 төгрөгийг тус тус зарцуулж, хамт олны шийдвэр, сайн дурын үндсэн дээр 2 алба хаагчид гэр, хашаа, газар, урьд ажиллаж байгаад нас барсан 1 алба хаагчийн гэр бүлд 1 удаагийн буцалтгүй 1,000,000 төгрөг, өөр хэлтсийн 5 алба хаагч, ажилтанд 1,100,000 төгрөгийг хандивласан.

Алба хаагчдын ажиллах, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор байгууллагынхаа 1, 2, 3 дугаар давхарын коридорын ханыг будах, таазыг угааж болдог шинэ хавтангаар солих, мэдүүлэг авах өрөөнүүдийг дуу тусгаарлах зориулалтай зөөлөвч материалаар бүрэх, алба хаагчдын өрөөний хаягийг шинэчлэн хийлгэх, жижүүрийн шуурхай албаны өрөөг засварлах, тавилаг эд зүйсийг шинэчлэх, зэрэг нийт 6,000,000 төгрөгний урсгал засвар хийж, эрүүлжүүлэх

саатуулах байранд 5 телевизор төсвийг шийдвэрлүүлэн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж ажилласан.

-Нийслэлийн цагдаагийн газрын тайланд зайлшгүй тусгуулах өөрийн байгууллагын хүрээнд болон бусад байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн шинэлэг ажил, арга хэмжээний талаар

Тус хэлтсээс багаар ажиллах бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор мөрдөн байцаах тасгаас санаачлан ахлах мөрдөгч нарт мөрдөгч нарыг тэцүү хуваарьлан багийн системд оруулан өрсөлдүүлж, сарын ажлаараа тасаг хамт олноо хошуучлан ажилласан алба хаагч болон багийг ажлын үр дүнгээр нь цалинг нэмэхийн зэрэгцээ дотоод нөөц бололцоо /хуримтлал/-нд тулгуурлан урамшуулж байх зохион байгуулалтын арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд хамт олноо хошуучлан ажиллаж хамгийн олон хэрэг шийдвэрлэсэн мөрдөгчийг гэр бүлийн гишүүний хамт кино театруудад саяхан нээлтээ хийж шинээр гарч байгаа уран сайхны кино, хошин шогийн продакшны шинэ уран бүтээлийн тоглолтыг үзэх эрхийн бичиг, өөрийн хариуцсан баг хамт олноо сайн зохион байгуулж, хамгийн олон хэрэг яллагдагчаар татаж шийдвэрлэсэн багт ус цэвэршүүлэгч, бичгийн цаас, бичгийн хэрэглэл зэргээр урамшуулсан нь алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээж, ажлын төлөө өрсөлдөх боломж нөхцөлийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлснээр Мөрдөн байцаах албаны хэмжээнд тус тасаг нь ажлаа 2019 оны эхний 11 сарын байдлаар тэргүүлсэн амжилтыг үзүүлсэн.

1.2 Хүний нөөцийн чиглэлээр:

-Алба хаагчдын дунд зохион байгуулсан сургалт, түүний үр дүнгийн талаар

Цагдаагийн нэгдүгээр хэлтэс: Байгууллагын хэмжээнд 2019 оны албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ажлын байран дахь сургалт, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан /өссөн дүнгээр/ 38 удаагийн 40 цагийн сургалтад давхардсан тоогоор 5462 алба хаагч хамрагдаж “E surgalt” санд мэдээллийг оруулсан.

“Байгууллагын 2019 оны сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 2019 оны биелэлтийг Цагдаагийн нэгдүгээр хэлтэс 90 буюу 4.5 оноотой дүгнэсэн.

-Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар

Алба хаагчдын чөлөөт зөв боловсон өнгөрүүлэх, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын ачаалал, стресс ядаргааг тайлах болон Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соёл, соён гэгээрүүлэх ажил” /код 940/ -ын 940.2.1-д заасны дагуу 2019 онд нийт 66 ажил, арга хэмжээг зохион байгуулж, 9961 алба хаагчийг хамруулсан.

“Хэлтсийн 2019 оны соён гэгээрүүлэх, спорт, урлагийн тэмцээн уралдаан зохион байгуулах ажлын салбар төлөвлөгөө”-ний 19 ажил, арга хэмжээний биелэлтийг энэ 2019 оны байдлаар гаргаж 86 оноотой 4 хувьтай дүгнэж, холбогдох газарт хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын түүх судлалын эрхлэгчийг урьж, цагдаагийн байгууллагын болон Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн түүхэн замналаар 160 алба хаагчдад сургалт, мэдээлэл зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын болон Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн түүхэн замнал, компьютер дээр суурилсан мэдээллийн систем, программ хангамж болон программ хангамжийг хэрэглэн мэдээллийг хувиргах, хадгалах, хамгаалах, боловсруулах, дамжуулах болон хүлээн авах, унадаг дугуй ба эрүүл мэнд зэрэг сэдвээр нийт 7 удаагийн 7 цагийн сургалт, мэдээлэл тус тус явуулж давхардсан тоогоор 1080 алба хаагч хамрагдсан байна.

Тус цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах, хэрэг бүртгэх тасгийн алба хаагчдыг Дотоод хэргийн их сургуулийн музей, Мөрдөх албаны тэнхим, Гадаад хэлний тэнхим, Албаны тусгай

бэлтгэлийн тэнхим, шинээр байгуулагдсан Хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах сургалт, мэдээллийн лабораторийн үйл ажиллагаатай танилцуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан хүндийн өргөлт, жүдо бөх, чөлөөт бөхийн тэмцээнд алба хаагчдаас оролцож, 5 алт, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах хүндийн өргөлтийн тэмцээнээс 1 алт, 1 мөнгөн медаль хүртсэн амжилттай оролцсон.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын 2019 оны аварга шалгаруулах болон Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Хэрэг бүртгэх алба, Нийслэлийн цагдаагийн газраас зохион байгуулсан Сагс, Гар бөмбөг, Самбо бөх, Ширээний теннис, Унадаг дугуйны, хөл бөмбөгийн тэмцээнд алба хаагч нарыг идэвхтэй оролцуулсан.

-Гадаад улсруу алба хаагчдыг сургалтад хамруулсан байдал, хүргүүлсэн саналын талаар

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсын НҮБ-ын энхийг сахиулах “UNMISSUNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнд орж үүрэг гүйцэтгэхээр цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 1 алба хаагч сонгон шалгаруулалтад тэнцэж, ажиллагаанд явсан.

Тус хэлтсээс 1 алба хаагч Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дугаар Б/943 тушаалаар Филиппин улсын CELI сургуулийн англи хэлний бэлтгэлд 2019 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд суралцсан. Хэлтсийн гадаад хэлний мэдлэгтэй алба хаагчдын судалгааг гаргаж НЦГ-т хүргүүлсэн.

-Хүний нөөцийн бодлогын талаар /томилогдсон, чөлөөлөгдсөн, хүний нөөцийн нөхөн хангалт хийсэн батлагдсан орон тоо, дутуу орон тоо

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2019 оны 02, 03, 07 дугаар тогтоолоор “Цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдэж, Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуулийг “Цагдаа”, “Цагдаа жолооч” мэргэжлээр төгссөн 17 иргэнийг тус хэлтсийн эргүүлийн цагдаа, эргүүлийн цагдаа жолоочийн албан тушаалд томилуулах саналыг Нийслэлийн цагдаагийн газрын Хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлснээр шийдвэрлүүлсэн.

Тус хэлтсээс 2018 онд ажлын үзүүлэлтээрээ А, В үнэлэгдсэн 2019 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэгдэх хүсэлт гаргасан болон болзол шаардлагыг хангасан 30 алба хаагчийг нөөцөд оруулах боломжтой эсэхийг “Албан тушаал дэвшүүлэх /код-909/”-д заасны дагуу судлан шаардлага хангасан алба хаагчдыг албан тушаал дэвшүүлэх нөөцөд авах жагсаалтын дагуу холбогдох судалгааг гарган Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлж, нөөцөд авагдсан алба хаагчдаас сул орон тоонд томилуулах саналыг хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/194 тушаалаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбоотойгоор 103 офицер, 91 ахлагч, 9 энгийн ажилтан, нийт 203 алба хаагчийн орон тоотой болсон, одоогийн байдлаар офицер-7, ахлагч 8 нийт 15 орон тоо дутуу байгаа нь орон тооны нөхөн хангалт **92.2** хувьтай, хүний нөөцийн талаар тогтвортой байна.

Тус цагдаагийн газрын албан тушаалын сул орон тоонд 2019 онд шинээр томилогдсон 27 алба хаагчдад сургагч-алба хаагчийг тушаалаар томилж, халамжлан хүмүүжүүлэгч сургагч багшийн гэрээг байгуулж, ажиллах нөхцөл бололцоогоор хангасан.

-Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөө /2017-2019 он/-г хэрэгжүүлж, 2019 оны жилийн эцсийн биелэлтийг 97 хувьтай дүгнэж, дүнг холбогдох газарт хүргүүлсэн.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаарх мэдээллийн 3 самбарыг хэлтсийн хүлээлгийн танхимд байршуулж, сурталчилсан.

Алба хаагчдын албанд ашиглаж буй таблетад авлигатай тэмцэх чиглэлээр шторк, видео бичлэгийг суулгаж, Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд “Авлигын эсрэг нэг өдрийн хөтөлбөрт сургалт”-д 24 алба хаагчийг хамруулсан.

Албан тушаал дэвшсэн, шилжин ирсэн 14 алба хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэгийг тус тус хуулийн хугацаанд шинэчлэн гаргуулж баталгаажуулсан.

1.4 Сахилга хариуцлага, дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын чиглэлээр

-Алба хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар

Тус цагдаагийн хэлтсээс 2019 оны 1, 2, 3 дугаар улирлын сахилгын зөвлөгөөнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 396 алба хаагч хамрагдсан ба зөвлөгөөнийг шинэлэг байдлаар буюу алба хаагчдаас өмнө авсан судалгааны дүнг танилцуулж, анхаарах асуудал, өөрийгөө стрессээс хэрхэн ангижрах аргуудын талаар, ахмад алба хаагчдаас туршлага солилцох, амьдралд тохиолдсон сургамжтай болон мартагдашгүй үйл явдлын талаар мэдээлэл хийж, харилцан ярилцаж санал бодлоо солилцон зөвлөгөөний шийдвэрийг гаргаж, шийдвэрийн хүрээнд тодорхой ажил, арга хэмжээ авч ажилласнаар эхний 11 сарын байдлаар сахилгын зөрчил **18 нэгжээр** буюу **-62 хувиар буурсан**.

Тус газрын алба хаагчдаас сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 12 заалт бүхий баталгааг 160 алба хаагчаас, бичгээр гаргуулан авсан. Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр сахилгын хариуцлагын зөвлөгөөнийг шинэлэг байдлаар зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Тус хэлтсээс багаар ажиллах бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор мөрдөн байцаах тасгаас санаачлан ахлах мөрдөгч нарт мөрдөгч нарыг тэцүү хуваарьлан багийн системд оруулан өрсөлдүүлж, сарын ажлаараа тасаг хамт олноо хошуучлан ажилласан алба хаагч болон багийг ажлын үр дүнгээр нь цалинг нэмэхийн зэрэгцээ дотоод нөөц бололцоо /хуримтлал/-нд тулгуурлан урамшуулж байх зохион байгуулалтын арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд хамт олноо хошуучлан ажиллаж хамгийн олон хэрэг шийдвэрлэсэн мөрдөгчийг гэр бүлийн гишүүний хамт кино театруудад саяхан нээлтээ хийж шинээр гарч байгаа уран сайхны кино, хошин шогийн продакшны шинэ уран бүтээлийн тоглолтыг үзэх эрхийн бичиг, өөрийн хариуцсан баг хамт олноо сайн зохион байгуулж, хамгийн олон хэрэг яллагдагчаар татаж шийдвэрлэсэн багт ус цэвэршүүлэгч, бичгийн цаас, бичгийн хэрэглэл зэргээр урамшуулсан нь алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээж, ажлын төлөө өрсөлдөх боломж нөхцөлийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлснээр Мөрдөн байцаах албаны хэмжээнд тус тасаг нь ажлаа 2019 оны эхний 11 сарын байдлаар тэргүүлсэн амжилтыг үзүүлсэн.

Алба хаагчдын үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлт, сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажил үүргээ хариуцлагатай, нэр төртэй биелүүлэх чиглэлээр хэлтсийн удирдлагаас сар бүр уулзаж, хугацаатай үүрэг өгч, биелэлтэд хяналт тавин ажилласан.

Цагдаагийн ерөнхий газраас , 2019 онд дэвшүүлсэн зорилтыг хэргэжүүлэх, алба хаагчдад зорилго, зорилтыг утга агуулгыг таниулах зорилгоор конторын алба хаагчдад зорилт болон түүний тайлбарын эхийг бэлтгэн хэвлэн өгч өрөө бүрт байрлуулсан.

Тус цагдаагийн хэлтсээс 2019 оны 1, 2, 3 дугаар улирлын сахилгын зөвлөгөөнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 396 алба хаагч хамрагдсан ба зөвлөгөөнийг шинэлэг байдлаар буюу алба хаагчдаас өмнө авсан судалгааны дүнг танилцуулж, анхаарах асуудал, өөрийгөө стрессээс хэрхэн ангижрах аргуудын талаар, ахмад алба хаагчдаас туршлага солилцох, амьдралд тохиолдсон сургамжтай болон мартагдашгүй үйл явдлын талаар

мэдээлэл хийж, харилцан ярилцаж санал бодлоо солилцон зөвлөгөөний шийдвэрийг гаргаж, шийдвэрийн хүрээнд тодорхой ажил, арга хэмжээ авч ажилласнаар эхний 11 сарын байдлаар сахилгын зөрчил **18 нэгжээр** буюу **-62 хувиар буурсан** үзүүлэлттэй байна.

Энэ онд 3-аас дээш удаа ажлаас хоцорсон, тасалсан, 2-оос дээш удаа сарын үндсэн цалинг бууруулсан, зөрчил дутагдал гаргасан, прокурорын “Шаардлага” болон албан бичигт нэр дурьдагдсан давхардсан тоогоор 36 зөрчилд 36 алба хаагчид “Сануулах хуудас” өгч бичгээр “Баталгаа” гаргуулсан.

-Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар

Цагдаагийн газрын хэмжээнд 2019 онд иргэд, аж ахуй нэгж байгууллагаас алба хаагчтай холбоотой 29 өргөдөл гомдол ирүүлснийг хуулийн хугацаанд шалгаж, 26 өргөдөл, гомдлыг шийдвэрлэн хариуг албан бичгээр хүргүүлж, 3 өргөдөл, гомдлыг шалгах ажиллагаанд үдэгдлээр бүртгэгдсэн.

Мөн 2019 онд иргэд, байгууллагаас цагдаагийн газар, хэлтсүүдийн удирдлагад хандан Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төв, ub1200.mn цахим хуудас, 1800-1200 тусгай дугаарын утас, check my service аппликейшнээр алба хаагчтай холбоотой 17 гомдол, 1 хүсэлт, 11 талархал ирүүлснийг хүлээн авч шалган шийдвэрлэсэн.

Үүнээс 7 гомдол, 2 хүсэлт хүлээн авч хуулийн хугацаанд нь шалгаж 6 гомдол, 2 хүсэлтийн хариуг албан бичгээр хүргүүлж, шалгах ажиллагаанд 1 гомдол байна.

Алба хаагчдаас 2019 онд удирдах албан тушаалтанд хандаж нийт 140 өргөдөл гаргаснаас ажилд орох, захиргааны чөлөө хүссэн-30, бусад-110 өргөдөл, хүсэлт байна. Үүнээс 140 өргөдлийг шийдвэрлэсэн байна.

-Эрүүл ажлын байрны орчинг бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар.

“Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус цагдаагийн хэлтсээс 110 алба хаагч эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, биеийн тамир, спортын арга хэмжээнд давхардсан тоогоор 2156, соён гэгээрүүлэх, сургалтын арга хэмжээнд 891 тус тус хамрагдсан.

“Зөв хооллолт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хорт зуршлаас татгалзах нь” сэдэвт гарын авлагыг 10 цэгүүдэд тараан байршуулж, 2019 оны 08 дугаар сарын 09-15-ны өдрүүдэд хаагчдын ажлын байранд очиж зөв хооллолтын талаар яриа таниулга хийж, зөвлөгөө өгсөн.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн сэтгэц клиниктэй “Архи, тамхины хор нөлөө” сэдвээр сургалтыг 148 алба хаагч 1 цагийн сургалт зохион байгуулсан.

“Эрчүүд ба гэр бүл” төрийн бус байгууллагатай хамтран 2019 оны 09 дүгээр сард “Архи ба гэр бүл” сэдэвт 1 цагийн сургалтыг 152 алба хаагчдад зохион байгуулж, архины хор уршигийн талаар бодит жишээ баримтаар сонирхолтой байдлаар зохион байгуулсан.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, дүүргийн Онцгой байдлын комисстой хамтран “Аюулгүй ажлын байр” 1 цагийн сургалтыг зохион байгуулж, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын чиглэлээр санамж сэрэмжлүүлэг тараасан.

Алба хаагчдын харилцаа, хандлага, сэтгэл ханамжийг дээшлүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байрны ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор байгууллагынхаа 1, 2, 3 дугаар давхарын коридорын хана, таазыг угааж болдог шинэ хавтангаар солих, мэдүүлэг авах өрөөнүүдийн хаалгыг дуу тусгаарлах зориулалтай зөөлөвч материалаар бүрэх, алба хаагчдын өрөөний хаягийг шинэчлэн хийлгэх, жижүүрийн шуурхай албаны өрөөг засварлах, тавилаг эд зүйсийг шинэчлэх, зэрэг нийт 19,000,000 төгрөгний урсгал засвар хийж, эрүүлжүүлэх саатуулах байранд 5 телевизор төсвийг шийдвэрлүүлэн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж ажилласанцагдаагийн гуравдугаар хэлтэст Фитнесийн иж бүрэн тоноглол бүхий танхим байгуулсан.

Дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус зөвлөлийн ажлыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар

“Эрсдэлийн менежментийн 2019 оны төлөвлөгөө”-г баталж, 2019 оны жилийн эцсийн байдлаар биелэлт 80 хувьтай тооцогдож, дүнг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр 25 з²-6277 дугаартай албан бичгээр холбогдох газарт хүргүүлсэн.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх яриа таниулгыг 1 удаа зохион байгуулж, 49 алба хаагчийг тарваган тахлын вакцинд хамруулсан.

Байгууллагын өрөө, тасалгаа, гадны хүчин зүйлийн нөлөөллийн судалгааг гаргаж, Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны цагдаагийн хэсгийн байранд урсгал засварыг хийсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/57 дугаар тушаалаар батлагдсан “Итгэлцлийн гэрээ”-г алба хаагчийн сахилга, ёс зүйг сайжруулах, өргөсөн тангарагтаа үнэнч байж, бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэж, шударга, зарчимч, ёс зүйтэй шуурхай, мэргэшсэн үйл ажиллагааг хэвшүүлэх зорилгоор тус хэлтсийн удирдлагаас алба хаагчидтайгаа 2019 оны 02 дугаар сард байгуулсан. Гэрээ байгуулсантай холбогдуулан итгэлцлийн гэрээний мөн чанар, ач холбогдол, үүсэх үр дагаврын талаар алба хаагчдад мэдээлэл хийж, хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2.1 Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд:

-Тухайн дүүргийн хэмжээнд үйлдэгдсэн зөрчлийн мэдээ, хэв журмын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч зохион байгуулсан ажил арга хэмжээний үр дүн болон цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар

Хариуцсан нутаг дэвсгэрт хоногийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэлд 14 хоног тутам дүн шинжилгээ хийж, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэргийн гаралтыг бууруулах зорилгоор 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Мэдэгдэл-Хяналт шалгалт ерөнхий арга хэмжээ зохион явуулах тухай” А/02 дугаар тушаалыг гаргаж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, мэдэгдэлд заасан ажил, арга хэмжээг зохион байгуулаагүй, хууль тогтоомжид заасан шаардлагад хүрээгүй зөрчил заагдсан 45 аж ахуйн нэгжийн зөрчлийг арилгуулж, 40 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулсан.

Хариуцсан хороодын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа, авто эргүүлийн амарч байгаа ээлжийн алба хаагч, олон нийтийн цагдаа нар 66 удаа 10560 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, Зөрчлийн тухай хуулиар 2167 иргэнийг 59.495.000 төгрөгөөр, 8 аж ахуйн нэгж байгууллагыг 3.100.000 төгрөгөөр торгож, 2773 сэжигтэй иргэн, 648 тээврийн хэрэгсэл, 515 аж ахуй нэгж байгууллагыг шалгаж, ар гэртээ болон гудамж талбай олон нийтийн газарт согтуугаар агсам тавьж танхайрсан 2906 иргэнийг тус хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байранд хүлээлгэн өгч, 1670 хүнээс 6.762.250 төгрөгний төлбөр төлүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон ахуйн хүрээнд согтуугаар агсам тавьж танхайрсан 128 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар шүүхээр баривчлуулж, архинд донтох өвчтэй 7 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулж ажилласан.

Тайлангийн хугацаанд цагдаагийн гуравдугаар хэлтсээс 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд “Бүлэг-2” нэгдсэн арга хэмжээн зохион байгуулж, энэ оны дугаартай дээрэмдэх 25 хэрэг бүртгэгдсэнээс 13 хэргийг илрүүлэн яллагдагчаар татаж мөрдөн байцаах тасаг шилжүүлэн ажилласан.

Камер техникийн хяналтын үйл ажиллагааны талаар /гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх зорилгоор теле камерын ашиглалтыг дээшлүүлэх, өргөжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, үр дүнг тооцсон байдал, нутгийн захиргааны байгууллагаар төсөв хөрөнгө, шийдвэрлүүлэхээр хамтран ажилласан байдал/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 2019 онд худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний 8.2.3.3-д заасны дагуу тус дүүргийн 4, 5, 14 дүгээр хороодод нийт 1.4 тэрбум

төгрөгийн өртөг бүхий гудамж, зам, талбайн камержуулалтын ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Санхүү, аж ахуйн албанд тус тус телекамерийг байрлуулах байршлын саналыг хүргүүлсэн.

Камерын шонг 8 аж ахуй нэгж байгууллагын хашаанд байрлуулах зөвшөөрлийг авч холбогдох байгууллагад мэдэгдсэн.

Хэсгийн байцаагчийн ажил үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар / хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн/

Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр А/01 дугаартай тушаалаар Байнгын ажлын хэсэг байгуулах тушаалаар гэр бүлийн хүчирхийлэл, урьдчилан сэргийлэх ажлын хэсгийн ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн хороо хариуцсан хэсгийн байцаагчид дэмжлэг үзүүлэх хуваарийг газрын даргаар батлуулан гарган Баянзүрх дүүргийн цагдаагийн нэг, хоёр, гуравдугаар хэлтсийн ахлах байцаагч, чиглэлийн ахлах ажилтан нараар хороон дээр ажиллуулж, шийдвэрлэхэд хүндрэлтэй, удаашралтай байгаа зөрчлийн хэрэг материалуудыг шалгуулж, өдөр тутуам зааварчилгаа өгүүлж ажилласан.

Хороодын Засаг дарга нартай уулзаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа нартай хамтран ажиллах төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Хороо хариуцсан 9 хэсгийн байцаагчийн ажлыг шалган зааварчилж, хэсгийн байцаагч нараас “Захиргааны туслах тоо бүртгэл” мэдээллийн системд оруулж байгаа мэдээлэлд тухай бүр хяналт тавьж, хороодын Чиглэлийн ахлах ажилтан нарт зааварчилгаа өгч, үр дүнг тооцож, ажилласан.

Хороо хариуцсан хэсгийн байцаагч нарыг хариуцсан хорооны нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулах, гар дээр шалгагдаж байгаа зөрчлийн ачааллыг багасгах зорилгоор 3 эргүүлийн офицерыг хэрэг бүртгэгчээр ажиллуулсан.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар / хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагад мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалт хийх, үр дүнг тооцох, Тухайлбал Эмзэг цэг тооцоо судалгааг тайлагнах/

Тус хэлтсээс ахуйн хүрээнд архидан согтуурах, гудамж талбай олон нийтийн газарт согтуугаар танхайрах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Архигүй өдөр”, “Эмзэг цэг-хяналт шалгалт”, “Хяналт шалгалт”, “Хуулийн хэрэгжилт”, “Эргүүл” зэрэг нэгдсэн болон тусгайлсан арга хэмжээнүүдийг зохион байгуулж, давхардсан тоогоор 880 чиглэлд 1760 цагдаагийн алба хаагч, 4 машинт эргүүлийн алба хаагчид 5760 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 1636 аж ахуйн нэгж байгууллага, 1404 иргэн, 661 тээврийн хэрэгсэл шалгаж, зөрчил гаргасан 8701 зөрчилд 376,123,005 төгрөгөөр шийтгэлийн хуудсаар торгож, ар гэртээ агсан согтуу тавьсан 670 хүнийг шүүхийн шүүгчийн захирамжаар 7-30 хоног баривчилж, орон гэртээ болон гудамж талбайд согтуугаар танхайрсан 11865 иргэн эрүүлжүүлэгдсэнээс 6818 иргэнээс 28,297,991 төгрөгний төлбөр төлүүлсэн.

Гудамж талбай, олон нийтийн газар болон ахуйн хүрээнд байнга архидан согтуурч танхайрдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг этгээдүүдэд 11 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлэн шүүгчийн шийтгэвэрээр 7-30 хоногийн баривчлах шийтгэл оногдуулж, 12 иргэнийг 1,200,000 төгрөгөөр торгож ажилласан.

“Архины албадан эмчилгээ” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, архины эмчилгээнд явуулахаар 14 иргэнийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд оруулж, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэвэрээр архины эмчилгээнд хамруулсан.

“Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг түр тогтоох тухай” Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/609 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 91 дүгээр тогтоол хэрэгжилтийг хангах чиглэлээр 12 удаа хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 554 аж ахуйн нэгж байгууллагыг шалгасан.

Эргүүлийн үйл ажиллагааны талаар зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар

Тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил, дуудлага мэдээллийг долоо хоног бүрийн “Даваа” гарагт гаргаж, эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдсэн газруудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэлтсийн нийт алба хаагчдыг хариуцсан хороодын нутаг дэвсгэрт долоо хоногийн “Баасан”, “Бямба”, “Ням” гарагуудад 23:00 цагаас 05:00 цаг хүртэл хугацаанд явган эргүүлд ажиллуулж, хөдөлгөөнт эргүүлийн хоногийн хугацаанд авах ачааллыг тэнцвэржүүлэх, дуудлага, мэдээлэлд цаг алдалгүй очиж ажиллах зорилгоор чиглэлийн ахлах ажилтан, ахлах байцаагч, хэсгийн байцаагч, цагдаа жолооч нарыг нэмэлтээр 18:00 цагаас 03:00 цагийн хугацаанд дуудлага, мэдээлэлд ажиллах хуваарийг хэлтсийн даргаар батлуулан ажилласан.

Нийт 56 удаа нэгдсэн болон хэсгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, арга хэмжээнд давхардсан тоогоор 368 офицер, 596 цагдаа, 84 олон нийтийн цагдаа хамрагдсан ба 42 гэмт хэргийг үйлдэл дээр нь илрүүлж, гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил 36.8 хувиар буурсан, эргүүлийн чиглэл дээр ямар нэгэн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдээгүй нь үр дүнтэй гарсан.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны талаар / олон нийтийн болон оюутан цагдаа, олон нийтийн цагдаагаас тухайн сард ажилласан үр дүнг тооцон тайлагнах/

Тус цагдаагийн хэлтэст 10 олон нийтийн цагдаа ажиллахаас 1 ээлжийн амралттай, 2 олон нийтийн цагдаа шинээр томилогдсон. Шинээр томилогдсон 2 олон нийтийн цагдаад сурган дадлагажуулахаар хэсгийн байцаагч нарыг ажлыг томилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү хэв журмын нөхцөл байдалд уялдуулан авто эргүүлийн алба хаагч болон олон нийтийн цагдаагийн ажилтны хамтарсан эргүүлийг өдрийн цагаар 8 цагийн хугацаагаар тогтмол зохион байгуулж, хэсгийн байцаагч болон цагдаагийн алба хаагчийн өдөр тутмын удирдлаган дор ажиллуулсан.

Тус хэлтсийн олон нийтийн цагдаа нар нь гэмт хэрэг, зөрчлийн талаар цагдаагийн байгууллагад болон холбогдох байгууллагад танилцуулсан 32, нийтийн хэв журам хамгаалах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдэд зохион байгуулж ажилд оролцсон байдал 5, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл, шалгалтыг хэсгийн байцаагч, хороон цагдаа, авто эргүүл, алба хаагч нарын хамт тогтмол зохион байгуулж ажилласан.

Хэсгийн байцаагч, хороон цагдаа, олон нийтийн цагдаа нар нь тус бүр хариуцсан хорооны задгай гэх хаягтай, бүлэг бөөгнөрөл үүсгэдэг айл өрх, хороодын эмзэг цэгүүдийн шинэчилсэн судалгааг гаргаж тэдгээр цэгүүдэд тогтмол эргүүлийн үүрэг гүйцэтгэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар айл өрхүүдээр давхардсан тоогоор 51531 иргэн, 22240 аж ахуй нэгж байгууллагад ухуулга яриа таниулга хийж, хамтарч ажилласан.

-Олон нийтийн цагдаа нар 2019 онд 12672 цагийн үүрэг гүйцэтгэж, 7 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд ажиллаж 27 зөрчил, 2 хэрэг илрүүлэн ажилласан.

-“Оюутан эргүүл” хэсэгчилсэн арга хэмжээг “Их засаг олон улсын их сургууль”, “Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль”-ийн давхардсан тоогоор 280 оюутныг 2019 оны 04 дүгээр сард буюу 1 сарын хугацаанд 2, 21, 27 дугаар хорооны хулгайлах гэмт хэрэг, зөрчил ихээр гардаг эмзэг цэгүүдэд давхардсан тоогоор 150 чиглэлд 300 алба хаагч 320 оюутануудтай явган эргүүлийн 1800 хүн цагийн үүрэг гүйцэтгэж сэжигтэй хүн 34 тээврийн хэрэгсэл 124 аж ахуйн нэгж байгууллагын харуул манаа 30, дэлгүүр 82 шалгаж, 4 зөрчлийг илрүүлж материалжуулан хариуцлага тооцон ажилласан.

Захиргааны хяналтын үүргийн хэрэгжилтийн талаар /нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн бүртгэл тооллогод хяналт тавьж ажилласан талаар, галт зэвсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал/

Тус цагдаагийн хэлтсээс 951 галт зэвсгийг тоолж, цагдаагийн байгууллагын мэдээллийн санд оруулж ажилласан.

“Зэвсэг-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус хэлтсийн даргын 2019 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн А/03 дүгээр тушаалаар ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөөг батлуулж, 20 алба хаагчид аюулгүй ажиллагааны зааварчилга өгсөн.

Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлтэй иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг нэгдсэн тооллогод бүрэн хамруулах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрийн 9 хороонд бүртгэлтэй 995 галт зэвсэгтэй иргэдийн хаягийг алба хаагчдад хуваарьлан өгч, галт зэвсгээ бүртгүүлэх талаар мэдээллийг хүргэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд 1 удаа мэдээлэл хүргэж, 200 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тараасан.

Тус хэлтсийн хариуцсан 9 хорооны нутаг дэвсгэрт 2019 оны 11 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар нийт 995 галт зэвсэг улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаагаас 951 буюу 95.57% хувийг тооллогод бүрэн хамруулснаас гэрээт харуул хамгаалалтын 22, ангийн 887, спорт-сургалтын 70, үзмэр, цуглуулгын 16, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл 1, үүнээс 6.4 мм хүртэл 405, 6.5 мм-ээс дээш 518, үрлэн сумтай 28, шилжүүлсэн 0, шилжиж ирсэн 0. бүх төрлийн богино буу 53, ажиллагааны хувьд автомат болон хагас автоматаар бууддаг 58, холын зайд өндөр нарийвчлалтай буудах зориулалт бүхий галт зэвсэг 103, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл 1-ийг бүртгэж, ажилласан.

Гэрээт харуул хамгаалалтын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа явуулах журмын биелэлтэд хяналт тавих ажлын талаар /нутаг дэвсгэрийн хэмжээнд гэрээт харуул хамгаалалтын байгууллагыг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж ажиллуулсан байдал, үр дүн/

Тус хэлтсийн хариуцсан хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 25 гэрээт харуул хамгаалалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулж Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ын хэрэгжилт, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10.1-дэх заалтын хэрэгжилтэд тус тус хяналт тавьж ажиллахад зөрчил дутагдал илрээгүй болно.

Хуульд заасан захиргааны бусад хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлыг товч тайлагнах /цахим тоглоомын үйл ажиллагаанд хяналт тавьж зөрчил гаргасан этгээдэд торгуулийн арга хэмжээ авсан байдал

Хариуцсан хороодын нутаг дэвсгэрт цахим тоглоомын үйл ажиллагаа явуулдаг 9 газрыг шалгаж, Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, 5 дугаар хорооны 2 цахим тоглоомын газар нь үйл ажиллагааг бүр зогсоосон ба хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа 7 цахим тоглоомын газрын бүртгэлийн гэрчилгээ, ажлын байрны нөхцөл, галын аюулгүй байдлын дүгнэлт зэрэг бичиг баримтыг шалгахад заагдсан зөрчилгүй байсан.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтарч “Цахим тоглоом”, дүүргийн прокурортой хамтарч “Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” ерөнхий арга хэмжээний хүрээнд нийслэлийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 180, дэн болон зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг 40 аж ахуйн нэгж, саун массаж 10 аж ахуй нэгж, иргэдийн үйл ажиллагаанд офицер 60, цагдаа 120, олон нийтийн цагдаа 8, бусад төрийн байгууллагын 115 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр нэгдсэн үзлэг, шалгалтыг 350 удаа зохион байгуулж ажилласнаар Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт зааснаар / цаг хэтрүүлэн ажилласан/ 4 иргэнийг 200.000 төгрөгөөр торгож, Зөрчлийн тухай хуулийн 15.2.1/ төрийн албан хаагчийн шаардлага үл биелүүлсэн/ 15.2.2.1-ээр 5 иргэн, аж ахуй нэгжийг 1.250.000 төгрөгөөр торгосон. Нийт 9 иргэн, аж ахуй нэгжийг 1.450.000 төгрөгөөр, БЗД-ийн 22 дугаар хороо, 5 дугаар хороонд байдаг 2 цахим тоглоомын газрыг бүрэн хаалгаж ажилласан.

Тус хэлтэс нь “Хүүхэд-Хамгаалал” тусгай арга хэмжээний хүрээнд Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран 10 хороодын авто угаалгын газар, “РС” тоглоомын газар, Баянзүрх зах, Е март худалааны төв, шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаар шалгалт хийн хараа хяналтгүй эрсдэлт нөхцөлд байсан 03-16 насны нийт 9 хүүхдийг “Хүүхэд залуучуудын төв” тусгай цогцолборт хүлээлгэн өгч, хараа хяналт сул 28 бүртгэлд аван 6 хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажилласан.

Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн малын гоц халдварт өвчин гарсан зэрэг гэнэтийн аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэм сахиулах чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар

Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/88 дугаар захирамжийн дагуу гамшиг, аюулт үзэгдэл, ослоос хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэн хуулийн этгээд, томилгоот бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах сургах, дадлагажуулах зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 24, 25, 26-ны өдрүүдэд “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн үед Бүслэн хаах, Шалган нэвтрүүлэх, Мөрдөн шалгах, Холбоо, Санхүү хангамжийн, Эмнэлэгийн тусламжийн бүлгийг ажиллуулсан ба алба хаагчдын албаны болон хувийн бэлэн байдал, нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл, хамгаалалтын олс, галын хор, чанга яригч, баримтжуулах дүрс бичлэгийн камер, зургийн аппарат, бичиг хэргийн хэрэгсэл зэрэг бусад шаардлагатай техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангуулан амжилттай оролцсон.

-Нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтын чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар:

Шинэ он солигдох үеийн “Мөнгөн шөнө” цэнгүүний хамгаалалт, 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 01 дүгээр сарын 19-ний өдрүүдэд “Гахайн афирк мялзан” өвчин гарах үед, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2018 оны А/182 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2012 оноос өмнө хураагдсан, хэрэглэх хугацаа хэтэрсэн нийт 7945 ширхэг архи, 760 литр техникийн спиртийг 2019 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 10:00-12:30 цагийн хугацаанд БЗД-ийн 24-р хороо “Цагаан даваа”-ны хогийн цэгт устгах үе, Төрийн банкны салбаруудад 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 01 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд “Өндөр настаны хишиг” олгож, очер дарааллын хамгаалалт, Эх орончдын өдөрт зориулсан Хүчит бөхийн барилдаан Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо “Бөх”-ийн өргөөнд зохион байгуулагдах үеийн хамгаалалт, “Сар шинэ-2019”, “Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн 10, 19 тойргийн дахин сонгууль” 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс 03 дугаар сарын 23-ны өдрүүдэд зохион байгуулах үед, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”, “Азийн ардын урлагийн их наадам”, “Ардчилсан намаас зохион байгуулсан жагсаал цуглаан”, 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Улаанбаатар марафон-2019”, 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үед, 2019 оны 06 дугаар сарын 21-нд Үндэсний батлан хамгаалах Их сургуулийн төгсөлтийн арга хэмжээнд зориулсан ёслолын буудлага үйлдэх үед, “Монголын үндэсний их баяр наадам”, “Улаанбаатар үдэш” цэнгүүн, 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 25в/2830 тоот албан бичгээр ирүүлсэн Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд зориулсан “Спортын наадам”-ын хүрээнд дугуйн болон гүйлтийн тэмцээн, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/941, Дүүргийн засаг даргын 2019 оны А/370 дугаар захирамжийн дагуу 2019 оны хоёрдугаар ээлжийн цэргийн жинхэнэ албанд иргэдийг татах үйл ажиллагаа 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 14 дүгээр сургуулийн байранд 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулагдах үед, 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрийн хооронд Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо “Орентал”, “Амар” зочид буудалд БНХАУ-ын иргэд болон хураагдсан эд зүйлсийн хамгаалалт, “Эх орон дуудаж байна” жагсаал, цуглаан, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 12:00-16:00 цагийн хугацаанд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос зохион байгуулсан жагсаал, цуглаан, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 04:00-18:00 цагийн хугацаанд Баянзүрх дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, газрын албатай хамтран 13, 22 дугаар хороодын нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүйгээр худалдаа үйлчилгээ эрхэлдэг 22 ширхэг “ТҮЦ”-ийг нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлөх үеийн хэв журмын хамгаалалт, зэрэг 72 удаагийн хамгаалалтыг ямар нэгэн зөрчил дутагдалгүй авч

ажиллаж, давхардсан тоогоор 3216 алба хаагч 17865 хүн/цагийн үүрэг гүйцэтгэн ажилласан болно.

Дээрх хамгаалалтыг Цагдаагийн ерөнхий газар болон Нийслэлийн цагдаагийн удирдах газраас ирүүлсэн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу салбар төлөвлөгөө, хуваарь, алба хаагчдын хариуцах цэг, байршлыг нэр заан томилгоожуулж, гүйцэтгэх үүргийг тухай бүр тодотгон танилцуулж гарын үсэг зуруулан баталгаа бичүүлж, алба хаагчдын дүрэмт хувцас, гэрэл ойлгогчтой хантааз, агсамж, тусгай хэрэгсэл, борооны цув, гар чийдэн зэрэгт тухай бүр үзлэг шалгалт хийн илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь засуулан албаны бэлэн байдлыг хангуулж, хамгаалалтын төлөвлөгөөнд заасан газар, цагт алба хаагчдыг бэлэн цуглуулан аливаа тэмдэглэлт өдөр, баяр наадам, жагсаал, цуглааны үеийн хэв журам сахиулах хамгаалалтанд зөрчил дутагдалгүй ажилласан байна.

“Бүгд Найрамдах Солонгос Улсын ерөнхий сайдын айлчлал хийх үеийн хамгаалалт”, 2019 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 30-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний их хурлын дарга Мустафа Шинтоп Монгол улсад айлцах үед, 2019 оны 09 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч В.В.Путин тэргүүтэй зочид төлөөлөгчид Монгол Улсад айлчлах үеийн зэрэг төрийн болон гадаад орны өндөр дээд хэмжээний зочин төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, хэв журам сахиулах 3 удаагийн хамгаалалтыг ямар нэгэн зөрчил дутагдалгүй авч ажиллаж, давхардсан тоогоор 1920 алба хаагч 15360 хүн/цагийн үүрэг гүйцэтгэн ажилласан болно.

Нийслэлийн цагдаагийн удирдах газраас ирүүлсэн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу салбар төлөвлөгөө, хуваарь, алба хаагчдын хариуцах цэг, байршлыг нэр заан томилгоожуулж, гүйцэтгэх үүргийг тухай бүр тодотгон танилцуулж гарын үсэг зуруулан баталгаа бичүүлж, алба хаагчдын дүрэмт хувцас, гэрэл ойлгогчтой хантааз, агсамж, тусгай хэрэгсэл, борооны цув, гар чийдэн зэрэгт тухай бүр үзлэг шалгалт хийн илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь засуулан албаны бэлэн байдлыг хангуулж, хамгаалалтын төлөвлөгөөнд заасан газар, цагт алба хаагчдыг бэлэн цуглуулан аливаа тэмдэглэлт өдөр, баяр наадам, жагсаал, цуглааны үеийн хэв журам сахиулах хамгаалалтанд зөрчил дутагдалгүй ажилласан болно.

-Эрүү хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар

Тус хэлтсийн хариуцсан хороодын нутаг дэвсгэр дэх хоногийн нөхцөл байдлын судалгааг 7 хоног тутам гарган дүн шинжилгээ хийж, дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргын өгсөн зааварчилга, үүргийн дагуу явган болон авто эргүүлийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр сар бүрийн 01-ний өдөр “Архигүй өдөр” тусгай арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргын захирамжын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа нарыг тус тусын хариуцсан хорооны нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 85 иргэн, аж ахуйн нэгжийг шалгаж ажиллахад 22 дугаар хороо “Наран” дэлгүүр нь цагдаагийн албан хаагчийн тавьсан шаардлага биелүүлээгүй үндэслэлээр 250,000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авсан.

Дүүргийн 5 дугаар хороонд “Дуудлага мэдээлэл” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, хариуцсан хорооны нутаг дэвсгэрт оршин суух гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, дахин үйлдэж болзошгүй 14 иргэний оршин суух хаягаар очиж уулзан, баталгаа бичүүлэн авч, фото зургаар баримтжуулан ажилласан.

“Цохилт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, нийт 30 чиглэлд 62 алба хаагчийг эргүүлд гаргаж, арга хэмжээний хүрээнд 283 хүн, 155 аж ахуй нэгж, 41 түц, 54 тээврийн хэрэгсэл шалган, 6 иргэнийг асран хамгаалагчтанд нь хүлээлгэн өгч, 10 иргэнийг 125000 төгрөгөөр торгож ажилласан.

Орон байрны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор “Тээш” хэсэгчилсэн арга хэмжээг Дүүргийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 оны 5 сарын 3-10-ны өдөр зохион байгуулж ажиллав. Арга хэмжээний хүрээнд орон байрны хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг 5, 22, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт авто эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаар 08:00-17:00 цагийн хугацаанд гэр хорооллын гудамжинд эргүүл хийлгэн, гудамжинд автомашины тээш, багаажинд үзлэг хийлгэн, Замын цагдаагийн

хэлтсийн алба хаагчдыг гэр хорооллын уулзвар, гарцууд дээр зогсоон автомашинд үзлэг шалгалт хийлгэж ажиллав. Алба хаагчид нийт 104 автомашины тээш шалган, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 13 иргэнийг саатуулан, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 4 тээврийн хэрэгслийг харъяаллаар зөрчлийг шалгуулахаар шилжүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 98 жолоочид 1,950,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулан, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй 6 иргэнийг журамлан ажилласан байна.

“Зөв тусгал” нэгдсэн арга хэмжээг 2019 оны 5 сарын 1-31-ний өдөр хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж ажиллав. Арга хэмжээний хүрээнд 5 сарын 09-ний өдөр хэлтсийн үүдний танхимд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, 80 иргэнд хөдөлгөөний зорилгыг тайлбарлан өгч, зурагт хуудас 4 төрлийн 150 ширхэгийг иргэдэд тарааж ажиллав. Мөн арга хэмжээний хүрээнд хэлтсийн алба хаагчдыг хөдөлгөөнд нэгдүүлж, 150 алба хаагчийн фээсбүүк хуудасны зургийн хүрээг нь зөв тусгал хүрээгээр солиулан ажилласан. Хүүхдэд үйлчилдэг газрууд болох цахим тоглоомын газар, хүнсний дэлгүүр, тоглоомын төвүүдэд нийт 140 аж ахуйн нэгжид зөв тусгал хөдөлгөөний зурагт хуудсыг тарааж ажилласан. Хөдөлгөөнийг суртачлан Дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтануудыг, интернэт цахим тоглоомын үйлчилгээ эрхэлдэг 16 иргэнийг, Ерөнхий боловсролын 14, 44, Шавь цогоцлбор зэрэг сургуулиудын багш ажилтануудыг нэгдүүлж ажилласан.

“Цахим тоглоом” хэсэгчилсэн арга хэмжээг 5 сарын 13-ны өдрөөс 6 сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд 5 сарын 13-ны 21,00 цагаас 5 сарын 14-ний 02,00 цагийн хугацаанд хороо хариуцсан хэсгийн байцаагч, цагдаа нар 16 цахим тоглоомын газруудад хяналт шалгалт хийж, зөвшөөрөлгүй үйлчилгээ эрхэлж байсан 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авч, зөвшөөрлийн хугацаа дууссан 2 иргэний үйл ажиллагааг зогсоон ажилласан. Мөн арга хэмжээний хүрээнд 5 сарын 13-ны өдөр Цахим тоглоомын газруудад Засгийн газрын 410 тоот тогтоолыг мөрдөж ажиллах талаар зааварчлага 5 сарын 16-ны өдөр хариуг авч ажилласан. Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн сургалтын мэргэжилтэн, а/д Должинсүрэнтэй хамтран цахим тоглоом эрхлэгч иргэдэд объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, Засгийн газрын 410 тоот тогтоол, Зөв тусгал хөдөлгөөний чиглэлээр сургалт зохион байгуулж ажиллав.

“Эрдмийн баяр” хэсэгчилсэн арга хэмжээг 2019 оны 05 сарын 06-ны өдрөөс 06 сарын 10-ны хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд их дээд 9 сургууль, ерөнхий боловсролын 8 сургуулийн удирдлага багш, ажилтанууд, оюутан сурагчдад эрдмийн баяраа зүй зохистой тэмдэглэж өнгөрүүлэх талаар зөвлөмж өгч ажиллав.

Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа орон байрны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор “Ундаг дугуй” хэсэгчилсэн арга хэмжээг 2019 оны 6 дугаар сарын 12-14-ны өдрийн хооронд зохион байгуулж ажиллав. Арга хэмжээний хүрээнд 20 аж ахуй нэгжид албан шаардлага өгч, 5 чиглэлд 8 цагдаа 4 олон нийтийн цагдаа эргүүл гаргаж, 2 гэмт хэргийг үйлдэл дээр нь илрүүлэн ажилласан болно.

Нийт 56 удаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулаж, арга хэмжээнд давхардсан тоогоор 368 офицер, 596 цагдаа, 84 олон нийтийн цагдаа хамрагдсан бөгөөд 42 гэмт хэргийг үйлдэл дээр нь илрүүлж, нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсанаар гудамж талбай үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил тодорхой хувиар буурсан, эргүүлийн чиглэл дээр ямар нэгэн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдээгүй нь үр дүнтэй болсон болно.

2.2 Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой, бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар

- Тус хэлтсээс 2019 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар төлөвлөгөөг 3 дугаар сарын 1-ний өдөр батлуулж, бүтэн жилийн биелэлт 35 ажил 82 оноотой 4,2 хувьтай дүгнэгдэж, холбогдох нэгж рүү хүргүүлсэн.

-Биелэлтийн хугацаанд нэгдсэн 3, хэсэгчилсэн 26 арга хэмжээ, 18 үзлэг шалгалт, 40 сургалт, сурталчилгаа, 9 өдөрлөгт 3405 иргэн, 32 ААНБ хамрагдаж, 274 мэдэгдэл өгч 69 хариу авч, 40 төрлийн 654 шаардлага өгч, 439 хариуг авч ажилласан.

Хөршийн хяналтын бүлэг, хэв журмын урамшилт эргүүл, хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоосон цагдаагийн байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад өгсөн “Мэдэгдэл”, “Шаардлага” түүний үр дүнгийн талаар:

“Нийтийн эргүүл ажиллуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу тус хэлтсийн хариуцсан 9 хорооны нутаг дэвсгэрт 44 урамшилт эргүүл гудамж, талбай, олон нийтийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 540 хүн цагийн эргүүлд ажиллаж, 78 зөрчлийн талаар мэдээллийг хороо хариуцсан алба хаагчдад өгч ажилласан.

Урамшилт эргүүлийн үйл ажиллагааг сар бүр дүгнэж, урамшууллыг нь Нийслэлийн ЗДТГ-с олгосон.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны ажлын төлөвлөгөөнд гудамж, талбай, олон нийтийн газар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хөршийн хяналтын бүлэг” 17-г байгуулан оршин суугаа хорооны нутаг дэвсгэрт 7 хоногийн 2 өдөр, 2 цагийн хугацаанд эргүүл хийн ажиллаж байна. Хөршийн хяналтын бүлгийн ажилласан тайланг сар бүр НЦУГ-т хүргүүлэн үр дүнг нь тооцсон.

Хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 3 иргэнд хэсгийн байцаагч нар хяналт тавин, хяналтын прокурорт хувийн хэргийг танилцуулан ажиллаж байна. Энэ хугацаанд гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй.

Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн баталгаажилт, малын шилжилт хөдөлгөөнд урьдчилан сэргийлэх, хяналтын чиглэлээр хийсэн ажил арга хэмжээний талаар

Нарантуул ОУХТ-ийн Баялаг ундраа төвд махны худалдаа эрхэлдэг 62 иргэн ажилладаг бөгөөд эдгээр иргэдийг судалгаанд авч, хууль эрх зүйн мэдээллийг цаг тухайд нь өгч ажиллаж байна. Уг махны тасагт сүүлийн үеийн IP камер 3 ширхэгийг суурилуулж, хяналт тавин ажилласан.

Хүрээлэн байгаа орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил арга хэмжээний талаар

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлтсийн пэйж хуудсаар дамжуулан иргэдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, постер байршуулсан.

“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран 16 байгууллага, иргэнд ой хээрийн, объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 цагийн сургалтыг зохион байгуулж ажилласан. Хариуцсан нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 9 сургууль, их дээд 5 сургуулийн оюутнуудад болон 750 орчим иргэдэд ой хээрийн гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн гарын авлага 750 ширхэгийг тарааж ажилласан. Мөн Дүүргийн ГХУСАЗСЗ-тэй хамтран “Байгаль ээжээ хайрлая” нэртэй хүүхдийн зурагтай номыг 900 ширхэгийг хэвлүүлж иргэдэд тараан сурталчлах ажлыг зохион байгуулсан. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн 8 шторк, видео нэвтрүүлгийг байгууллагын цахим хуудсаар сурталчилж, 2400 гаруй хүн хандалт авсан.

Харьяа нутаг дэвсгэрт мод, модон материалын үйлдвэр, худалдааны төв байхгүй бөгөөд 2019 онд хүрээлэн байгаль орчны эсрэг гэмт хэрэг тус хэлтэст бүртгэгдээгүй.

Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй телевиз FM радио өдөр тутмын сонин сэтгүүл, сайтуудад хамтран ажиллах гэрээ байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах ажлын талаар

Нэгдсэн арга хэмжээний үед ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын цахим хуудсанд байршуулсан шторк, контентийг хэлтсийн цахим хуудас, угтах үйлчилгээний урсдаг Лед самбар, телевиз, 9 хорооны цахим хуудас, иргэдийг

хүлээн авах хэсгийн ухаалаг дэлгэц болон олон дагагчтай 15-20 цахим хуудсанд мэдээллийг түгээн байршуулсан.

Телевизээр 12 мэдээ, мэдээлэл өгсөн.

Эх орон телевизээр “Сар шинэ 2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд алба хаагчдаас илрүүлсэн хэргийн талаар мэдээлэл хийсэн.

МҮОНТ-д хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг хүргэсэн.

ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн төвд хариуцсан нутаг дэвсгэрт хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж байгаа ажлын талаар болон иргэдэд хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг хүргэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтарч 2019 оны 01 сарын 23-ны өдөр МҮОНРТ-ээр Нарантуул ОУХТ дээр хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг мэдээ, мөн ченж буюу гар дээрээс худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах зорилгоор сурвалжлага, мэдээлэл бэлтгэн ажилласан.

ТВ-9 телевизийн “Зочны цаг”-аар 2019 оны 02 сарын 02-ны өдөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар яриа өгсөн.

ТВ-5 телевизтэй хамтарч Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2019 оны 03 сарын 01-ний өдөр мэдээлэл бэлтгэж хүргэж ажилласан.

ТВ-9 телевизийн Мэдээний албатай хамтарч 2019 оны 03 сарын 14-ны өдөр Нэг хором хөдөлгөөний хүрээнд цагдаагийн хэлтсээс зохион байгуулж байгаа ажил, арга хэмжээний талаар мэдээлэл өгч ажилласан.

Зөв тусгал хөдөлгөөнийг сурталчилсан өдөрлөгийн арга хэмжээний үед Сүлд телевизтэй хамтран иргэдэд мэдээлэл түгээж ажилласан.

ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвтэй хамтарч 2019 оны 07 сарын 20-нд Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг гол усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл бэлтгэж 8 телевизээр иргэдэд түгээн ажиллаж байна.

“Хичээлийн шинэ жил” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулж байгаа ажлын талаар болон “Хүүхэд хамгаалагч” танилцуулга өдөрлөгийн талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвд 2019 оны 09 сарын 17-ны өдөр мэдээ бэлтгэн иргэдэд хүргэн ажилласан.

Ахлах мөрдөгч цагдаагийн хошууч П.Алтанзул нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хүүхэд хохирох болон холбогдохоос урьдчилан сэргийлэхтэй холбоотой ярилцалагыг ТВ5 телевизд 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр өгсөн.

Монгол HD телевизийн мэдээний албатай хамтран хоногт ирж байгаа гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн талаар сурвалжлага, мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэн ажилласан.

Ахлах мөрдөгч цагдаагийн ахмад В.Гангантөгс нь согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудад хийж байгаа хяналт, шалгалтын ажлын талаар ярилцалагыг ТВ5 телевизд 2019 оны 10 дугаар сарын 5-ны өдөр өгсөн. ФМ-107,5 радиод 2019 оны 01 сарын 18-нд хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, 2019 оны 2 сарын 09-нд Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурвалжлага, мэдээ өгч ажилласан.

MGL радиод Сар шинэ нэгдсэн арга хэмжээний хүрээнд хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэж ажилласан.

FM-107.5-ийн хуулийн цаг нэвтрүүлгээр 2019 оны 08 дугаар сарын 03-ны 10 цагт “Яараад яахав дээ” аяныг сурталчилж ажилласан.

ФМ-104 радиод Зөв тусгал хөдөлгөөний талаар мэдээлэл хүргэж ажилласан.

Сар шинэ, Нэг хором, Зөв тусгал хөдөлгөөн, Байгалиа хамгаалъя, Яараад яахав дээ, Хичээлийн шинэ жил нэгдсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрт байрлах төрийн байгууллагуудыг хөдөлгөөнд нэгдэж байгаа, сургалтанд хамруулж байгаа талаархи мэдээллийг Онцлох.мн, Шуурхай.мн зэрэг 12 сайтад байршуулж ажилласан.

Монгол Улсад зорчиж буй гадаадын иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион явуулж үр дүнг тооцсон байдал.

Хэлтсийн хариуцсан 9 хороодын нутаг дэвсгэрт түр хугацаагаар оршин суудаг гадаадын иргэдийн бүртгэл судалгааг 2019 онд хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаа нар нэг бүрчлэн тулгалт хийж, 25 иргэний судалгааг шинэчлэн цахим санд мэдээлэл оруулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн сүлжээ хуудас, байршуулж олон нийтэд хүргэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар

“Баянзүрх дүүргийн иргэдийн нэгдсэн групп”, “Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар” пейж хуудсаар олон нийтэд мэдээлэл, видео шторк зэргийг хүргэж байгаа ба тус пейж хуудас 10 мянган дагагчтай, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухуулга, нөлөөлөл, ажил, арга хэмжээний чиглэлээр 2019 онд нийт 130 мэдээлэл оруулж ажиллаж байна.

2.3 Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээ, үр дүнгийн талаар

2019-2020 оныг “Хүүхдийн хөгжил хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулан “Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн талаар цахим орчныг аюулгүй хэрэглэх зөвлөгөө, мэдээллийг БХИС-ийн харьяа Тэмүүжин-өрлөг сургуулийн 340 сурагчдад 2 удаа, Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг яриаг хийсэн. 44-р сургуулийн 8-12 дугаар ангийн 280 хүүхэд, Монгол тэмүүлэл сургуулийн 60 сурагч, Шинэ монгол сургуулийн 160 сурагч, Улаанбаатарын их сургуулийн 180 оюутан, БХИС-ийн ахлагчийн сургуултыг 80 оюутан нийт 1140 оюуцан сурагчдад яриа таниулга, сургалт хийсэн.

“Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” өдөр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч өдөрлөг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 29-ны 14 цагт Баянзүрх дүүргийн 24 хороо 6 дугаар хэсэгт байрлах Овоотын хүүхдийн тоглоомын талбайд “Хүчирхийлэлгүй хороо” сэдэвт өдөрлөг зохион байгуулах арга хэмжээнд хамтран ажилласан.

“Хүүхэд хамгаалагч” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 9 хороотой хороо бүр цагдаагийн байгууллагаас гавьяаныхаа амралтанд гарсан иргэдээс хүүхэд хамгалагчаар авч хүүхэд хамгаалагч төслийн нээлтэнд 9 хүнээ оролцуулж шар хантааз болон зааварчилгааг холбогдох зохион байгуулж байгаа ахлахууд хангаж ажилласан болно.

Хэлтсийн хэмжээнд ерөнхий боловсролын төрийн 9 сургуулийн захиргаа, эцэг, эх, асран хамгаалагчидтай “Хүүхэд хамгаалал”-ын чиглэлээр хамтран ажиллах “Гурвалсан гэрээ”-г байгуулж, үр дүнг тооцон ажиллаж байна. Тайлангийн хугацаанд тус хэлтсээс нийтийг хамарсан 2 удаагийн өдөрлөг, 20 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдийн төлөөлөл 1200 иргэн оролцсон байна.

Хариуцсан хороодын Засаг дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад “Хүүхэд хамгаалагч” төслийн талаархи зөвлөмжийг хүргүүлж Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Тэмүүжин Өрлөг дээд сургуулийн эцэг эхийн төлөөлөл 280 иргэн, засаг дарга, сургуулийн захирал, багш, ажилчидад яриа таниулга хийж тэдгээр оролцогчдоос саналыг нь авав.

Хүүхдийг болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх асран хамгаалагч олон нийтэд чиглэсэн зөвлөмж мэдээллийг нийт 20,000 дагагчтай фэйсбүүк 19 группт шторк мэдээллийг байрлуулж, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Нийслэлийн цагдаагийн газрын хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бэлтгэсэн зурагт контент 10, видео шторк 8, сэргийлэгч хүү, зөвлөгч охины зөвлөмж сэрэмжүүлэг 25, нэвтрүүлэг 2-г цахим хуудсанд нийтлэн, хандалт ихтэй цахим хуудсуудад байршуулсан. “Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлье” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд улирал бүр хариуцсан хороодын нутаг дэвсгэрт байрлах улсын -9, хувийн 6 нийт 15 сургууль, 30 цэцэрлэгийн болон нийтийн эзэмшлийн биеийн тамирын 9 талбай, хүүхдийн тоглоомын 12 талбайд жрдьчилан сэргийлэх чиглэлээр Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 9 хорооны Хүүхэд -хамгаалагч нарын хамт хамтран ажилласан.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн орчим амарч зугаалж байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын хэвлэл мэдээллийн төвтэй хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн цагдаагийн хошууч О.Пүрэвсүрэн миний бие 2019.07.05 өдөр “Амрыг эрье” нэвтрүүлэгээр MN, MN-2, TV-5, NTV, Боловсрол, эх орон, С1 телевизүүдээр иргэдэд зуны амралт болсонтой холбогдуулан урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжүүлэг мэдээ бэлтгэж хүргэсэн.

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн дотоод гадаад орчны аюулгүй байдал” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Дүүргийн боловсролын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, 2019 оны 04- дүгээр сарын 15–ны өдрөөс 2019 оны 04-дүгээр сарын 20-ны өдрүүдэд, 2019 оны 8 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 03-ныг хүртэл хүртэл хуваарийн дагуу нийт 2 удаа нэгдсэн шалгалтыг Ерөнхий боловсролын боловсролын 111, 114, 133, 136, 137, 44, 53, 55 дугаар сургууль, БХИС-ийн Тэмүүжин –өрлөг дунд сургууль, зэрэг төрийн ерөнхий боловсролын 9 сургууль, хувийн Гёте, Шинэ Монгол, Төгс дэлгэрэх, Глобаль, Плехановын сургууль, Улаанбаатар дунд сургууль зэрэг хувийн 6 сургууль, нийт Ерөнхий боловсролын 15 сургууль, улсын 115, 128, 172, 168 дугаар цэцэрлэгүүдийн гадаад, дотоод аюулгүй байдлыг шалгаж, нийгмийн ажилтан нарт үүрэг чиглэл өгч ажилласан.

Сургууль, цэцэрлэгийн болон нийтийн эзэмшлийн биеийн тамирын, хүүхдийн тоглоомын талбайн орчны гэрэлтүүлэгийг сайжруулах, гадна болон дотоод орчныг камераар хянах, нөхцлийг бүрдүүлэх, эрсдэлтэй тоног төхөөрөмж, тоглоомын хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх талаар Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, хороодын засаг дарга нарт шаардлага хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хариуцсан хороодын нутаг дэвсгэрт байрлах 15 сургууль гадна талд нийт 50 камер, дотор талдаа 105 камер байрлуулсан. 6 улсын, хувийн 90 цэцэрлэгийн гадна талд нийт 115 камер, дотор талдаа 270 камертай байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2019 оны 01/37 дугаартай “Нарантуул худалдааны төв , Сандэй худалдааны төв, баар, караоке зочид буудал, массаж, сауны газар, авто угаалгын газруудад насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтын дагуу урьдчилан сэргийлэх шалгалтыг 2019 оны 06 дугаар сарын 15-ноос, 6-сарын 25–ний өдрүүдэд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, Дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсийн Хөдөлмөр хяналтын улсын байцаагч, Гэр бүл , хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн хүүхдийн эрхийн улсын байцаагч нар хамтран зохион явуулсан.

Шалгалтын хүрээнд баар-8, караоке-6, дэн буудал-3, зочид буудал-1, саун массажны газар-1, Нарантуул зах, Авто угаалга-5-ийг тус тус шалгаж, Цагдаагийн ерөнхий газраас зохион явуулсан “Зөв тусгал” хөдөлгөөнд 21 аж ахуй нэгж байгууллагын 85 ажилчдыг нэгдүүлж, санамж сэрэмжлүүлэг 250, зөвлөмж 120 ширхэгийг тараан байршуулсан.

Шалгалтын явцад насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтын дагуу насанд хүрээгүй хүн ажиллуулсан авто угаалга 1, Нарантуул зах дээр худалдаа хийсэн 3 зөрчил илрүүлж, ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн.

“Эмзэг цэг”, “Яараад яахав дээ” нэгдсэн арга хэмжээ, “Илрүүлэлт”, “Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлье”, “Цахим тоглоом”, “Сэрэмжүүлэг”, “Эргүүл шалгалт”, “Өсвөрийн сэргийлэгч” “Амар тайван гэр бүлийн төлөө хамтдаа”, “Ломбард шалгалт”, “Архины албадан эмчилгээ”, “Хар тамхи мансууруулах бодис” зэрэг арга хэмжээг зохион явуулж ажилласан.

Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлье хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан хороодын нутаг дэвсгэрт байрлах 15 сургууль, 15 цэцэрлэгийн болон нийтийн эзэмшлийн биеийн тамирын 13 талбай, хүүхдийн тоглоомын 6 талбайд хүүхэд тоглох, спортоор хичээллэх үедээ бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хороо хариуцсан хэсгийн байцаагч, хорооны цагдаа, олон нийтийн цагдаа нар, хүүхэд хамгаалагч нарын хамт Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын байцаагч нарын хамт хамтарсан шалгалт хийж ажилласан.

Сургууль, цэцэрлэгийн болон нийтийн эзэмшлийн биеийн тамирын, хүүхдийн тоглоомын талбайн орчны гэрэлтүүлгийг сайжруулах, гадна болон дотоод орчныг камераар

хянах, нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлтэй тоног төхөөрөмж, тоглоомын хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх талаар шаардлага хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Ерөнхий боловсролын 111 сургууль, Плехановын сургууль, Шинэ монгол, 44-р сургууль, 55-р сургуулиудын нээлтийн арга хэмжээнд хүүхэд хамгаалагч нарын хамт оролцож гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийлээ.

“Өсвөрийн сэргийлэгч” чуулга уулзалт арга хэмжээний хүрээнд цагдаагийн 2,3-р хэлтэстэйгээ хамтарч Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлөөс Баянзүрх дүүргийн 340 “Өсвөрийн сэргийлэгч” нарт шар хантаазыг хийлгэж өгсөн. Сурагчдын хичээлийн хуваарийг 500 ширхэг хэвлүүлэн 09 дүгээр сарын 01 өдөр хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээн дээр сурагчдад гардуулж өглөө

Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар

Дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, “Хүүхэд хамгаалагч нартай хамтран “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019 оны 05 дүгээр сарын 10-ны өдрийн 12.00-16.00 цагийн хооронд Баянзүрх дүүргийн 4 хороо Жуковын талбайд зохион явуулсан. “Хүүхэд-Хамгаалал” төслийн хүрээнд НЦГ-өгсөн 2.000.000 төгрөгөөр 100 алба хаагч, 150 хорооны засаг дарга, сургуулийн захирал, нийгмийн ажилтан нарыг хамруулсан сургалт зохион байгуулсан. Дуучин Сөрөлтөөр ивээн тэтгүүлж Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 14 хорооны 1 хүүхдэд өвлийн гутал, өвлийн куртца, гурил будаа өгч ахуй амьдралд нь тусламж үзүүлэн ажилласан.

“Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлье” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Гэр бүл, хүүхэд хөгжлийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран хариуцсан хороодын нутаг дэвсгэрт байрлах 9 сургууль, 34 тоглоомын 6 талбайд хүүхэд тоглох, спортоор хичээллэх үедээ бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх шалгалт хийж, сургууль, цэцэрлэгийн болон нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон хүүхдийн тоглоомын талбайн орчны гэрэлтүүлгийг сайжруулах, гадна болон дотоод орчныг камераар хянах, нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлтэй тоног төхөөрөмж, тоглоомын хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх талаар шаардлага хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

“Хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 02 тоот албан даалгаврын хүрээнд 2019 оны 06 дугаар сарын 13,14-ны өдрүүдэд хүүхдийг аливаа осол гэмтэл, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг дүүргийн Мэргэжлийн хяналт, Боловсролын хэлтэс, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран 4 удаа шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Сургууль цэцэрлэгийн орчмыг Монгол улсын стандарт MNS 56444:2014 “Сургуулийн бүс, Техникийн ерөнхий шаардлага”-д нийцүүлэх арга хэмжээ авахаар Ерөнхий боловсролын 9 сургууль, Хувийн хэвшлийн 6 сургуулийн захирал, нийгмийн ажилтан нартай уулзаж, хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгч, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах гэрээг байгуулсан.

“Хүүхэд хамгаалагч”-ийн талаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын цахим хуудсанд хандсан нийт хандалт 1.039.213 удаа байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах чиглэлээр Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар цахим хуудас, Нийслэлийн цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Урьдчилан сэргийлэх ахлахууд фейсбүүк сайт, цахим хуудсуудад байршуулан, иргэд олон нийтэд сурталчлан ажилласан. Тус хэлтсээс хийж хэрэгжүүлж байгаа ажлуудыг 2019 оны хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвтэй хамтран “Амрыг эрье” нэвтрүүлгээр 3 удаа, ТВ-5 телевиз, NTV телевиз, FM-107.5-д тус тус хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглээр сэрэмжлүүлэг яриа өгч ажилласан.

Насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн хэрэг, зөрчлийн талаар /тоот мэдээ, шийдвэрлэлтийн байдал/

Тус цагдаагийн газарт 2019 оны эхний 11 сарын байдлаар насанд хүрээгүй этгээдээс 56 гэмт хэрэг үйлдсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад 36.5 хувиар өссөн.

2.4 Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр

Бүртгэгдсэн гомдол мэдээлэл, гэмт хэргийн талаар хариуцсан нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гомдол мэдээлэл, гэмт хэргийн тоо мэдээ, түүний шийдвэрлэлт, хэргийн илрүүлэлтийг урьд онтой харьцуулсан байх, гэмт хэргийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч үйдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүнг тооцсон байдал, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ

2019 оны эхний 11 сарын байдлаар иргэн, байгууллага, аж ахуй нэгжээс нийт 13835 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасаны 4017 буюу 29,0 хувь нь гэмт хэргийн, 9818 буюу 70,9 хувь нь захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Урд оны мөн үетэй харьцуулахад 84,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн хугацаанд бүртгэгдсэн 2076 хэргийн 2024 нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй ба 618 хэргийн сэжигтэнд ял сонсгож хэргийн илрүүлэлт **30,5** хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад **8,1** хувиар өссөн байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг харьяалал харгалзахгүйгээр түргэн шуурхай хүлээн авах, бүртгэх, материалжуулах, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх, гэмт хэрэг гарсан таслан зогсоох, илрүүлэх, ул мөрийг хамгаалах, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах, хойшлуулшгүй ажиллагаа, зохион байгуулалтын арга хэмжээг авч, мэргэжил, арга зүйгээр хангах мэдээнд орхигдсон, бүртгэлд авагдаагүй өргөдөл, гомдол, мэдээлэлд хяналт тавих зорилгоор тус цагдаагийн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Байнгын ажлын хэсэг байгуулах тухай” А/03 дугаар тушаалыг гаргаж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан.

Дээрх зохион байгуулалтын үр дүнд тус цагдаагийн газрын хэмжээнд 2019 оны эхний 11 сард 43316 дуудлага, мэдээлэл ирснийг урьд оны мөн үетэй харьцуулахад 2073 нэгжээр буюу 5,0 хувиар, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээлэл 33935 бүртгэгдсэн нь 13485 нэгжээр буюу 39,7 хувиар өссөн, гэмт хэргийн шинжтэй дуудлага, мэдээлэл 2223 бүртгэгдсэн нь 14118 нэгжээр буюу 6,3 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Хоногийн хугацаанд машинт эргүүлүүдээс дуудлага, мэдээллийг шалгасан нөхцөл байдал, ажлын ачаалал, шийдвэрлэлтийг харьцуулахад харилцан адилгүй байгаад дүгнэлт хийж, тэнцвэржүүлэх зорилгоор цагдаагийн хоёрдугаар хэлтсээс 1 эргүүлийн автомашин гаргаж, 3 хэлтэс тус бүрээс 2, нийт 6 алба хаагчийг 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 22:00-08:00 цагийн хооронд дуудлага, мэдээлэл ихээр ирж байгаа зарим хороодод дуудлага, мэдээллийг түргэн шуурай очиж ажиллах, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор 117, 118, 119 чиглэл гаргаж нэмэлтээр ахлах албан тушаалтнуудаас ажиллуулж байна.

Үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвгэрийн хэмжээнд 18 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулснаар эрэн сурвалжлагдаж байсан 3 сэрдэгдсэн этгээдийг олж тогтоон, гэмт хэрэг үйлдэж болзошгүй 28 этгээдийг бүртгэл судалгаанд авч, хэрэг бүртгэлийн шатанд шалгагдаж байгаа нийт 2318 хэргийн судалгаа гаргаж, алба хаагчидтай нэг бүрчилэн тулгалт хийж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг даруй илрүүлэх боломжтой, яллагдагчаар татагдвал зохих хүн нь тодорхой боловч хаана байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа хэргүүд, мөн хэрэг бүртгэлийн үндсэн хугацаанд шийдвэрлэх боломжтой хэргүүдийн судалгаа гаргаж 211 хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлж, 52 хэргийг яллагдагчаар татаж шилжүүлж, сумны 32, алт монетон эдлэлийн 26, эртний эдлэлийн 6, хуучин эдлэлийн 98 ченжийг шинээр бүртгэж, оргон зайлсан 2 этгээдийг эрэн сурвалжилж олж 9 холбогдогчтой 11 хэргийг шийдвэрлүүлсэн. Мөн халаасны хулгайн гэмт үйлдэж болзошгүй 14 этгээдийг судалгаанд авч, зөрчлийн 6 хэрэг илрүүлж, “Илрүүлэлт-оргодол-шийдвэрлэлт 2019” нэгдсэн арга хэмжээ зохион явуулах ажлын салбар төлөвлөгөө гарган хэлтсийн нийт алба хаагчдыг 9 багт хуваарьлаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласнаар 2145 хүн, 602 тээврийн хэрэгсэл, 54 нийтийн байр, 31 баар, 39 зочид буудал, 72 байгууллага, аж ахуйн нэгж шалгаж, эрэн сурвалжлагдаж байсан 1 оргодол, 25 сэрдэгдсэн этгээд, 13 тээврийн хэрэгсэл олж тогтоож, урьд цагдаагийн

байгууллагад бүртгэгдээгүй хэрэг **259** илрүүлж, ажиллагааны явцад хэрэг **189** илрүүлж, яллагдагчаар татсан **158** хэрэг, харьяаллын дагуу **74** хэрэг шилжүүлж, нийт шийдсэн хэрэг **-673**, оргодол-1, сэрдэгдсэн этгээд **25** олж тогтоож баривчлан, 28 халаасны хулгайн гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийг шалган, шинэчилсэн судалгаанд хамруулж, нийт 26,100,000 төгрөгний хохиролтой 9 холбогдогчтой 12 гэмт хэргийг илрүүлсэн. Тус хэлтэст шалгагдаж байгаа 386 залилах гэмт хэргийн судалгааг гаргаж, шийдвэрлэх боломжтой 77 гэмт судалгааг гарган хяналтын прокурорт танилцуулан, 70 хэргийг шийдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлтийн чиглэлээр хийсэн ажлын талаар

2019 оны эхний 11 сарын байдлаар гэмт хэргийн улмаас 2045 иргэн хохирч, үүнээс 33 хүн нас барж, 517 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 19,5 хувиар буурч, гэмтсэн хүн 18,9 хувиар буурсан.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 28,940,2 /сая төгрөгөөр/ төгрөгийн хохирол учирч 19,924,9 /сая төгрөгөөр/ буюу 68,8 хувийг нөхөн төлүүлсэн.

Хохирол нөхөн төлүүлэлт 2019 оны эхний 11 сарын байдлаар 19,924,9 / сая төгрөг/-ийг нөхөн төлүүлснийг өнгөрөн оны мөн үетэй харьцуулахад 9,6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Прокурорын байгууллагаас ирүүлсэн шаардлагын мөрөөр зохион байгуулсан ажил шалтгаан нөхцлийг тогтоох хариуцлага тооцох хариу хүргүүлсэн байдал хамтран сургалт зөвлөгөөн зохион байгуулсан ажил.

Эрүүгийн хэргийн хугацаа алдах, хэрэгт ажиллагаа хийлгүй дарагдуулах, прокурорын даалгаврын заалтыг биелүүлэхгүй байх зөрчлийг таслан зогсоох, шинээр томилогдсон мөрдөгч нарыг дадлагажуулах, гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэлтийг ахиулах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран ажил, арга хэмжээг зохион байгуулснаар тус хэлтсийн хэмжээнд 2019 оны эхний 11 сарын байдлаар Баянзүрх дүүргийн Прокурорын газраас 7 шаардлагад зөрчил заагдсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буюу 45.4 хувиар буурсан.

Тус хэлтсээс 2018 онд сахилгын арга хэмжээ авагдсан байдалд дүн шинжилгээ хийхэд ажлын хариуцлага алдсан, хэрэг материал дутуу шалгасан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн зэрэг зөрчил нийт зөрчлийн 15 буюу 51,74 хувийг эзэлж байгаад дүгнэлт хийж, хугацаа сунгасан, шүүх, прокуророос буцсан, удааширч байгаа шийдвэрлэгдээгүй хэргүүдийг дүүргийн Прокурорын газрын орлогч болон ахлах прокуроруудад танилцуулан хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхэд анхаарч даргын даалгавар бичин зааварчлах, ахлах мөрдөгч, мөрдөгчийн ажлын хэсэг томилж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласнаар тус хэлтсийн Мөрдөн байцаах тасаг нь ажлын үзүүлэлтээрээ Мөрдөн байцаах албаны хэмжээнд 2019 оны эхний 11 сарын байдлаар ажлаараа тэргүүлсэн үр дүн гарсан.

Прокурорын байгууллагаас 2019 онд ирүүлсэн шаардлага бүрийн мөрөөр алба хаагдыг дахин зөрчил гаргахгүй байх алдаан дээр суралцах, сургамж болгох зорилгоор сургалтын материал бэлтгэж, нийт мөрдөгч нарт, ахлах мөрдөгч нараар “Алба хаагчдын анхаарвал зохих асуудал”сэдвээр Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах Хэрэг бүртгэх, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагч сургалт зохион байгуулсан.

Эрэн сурвалжлагдаж байгаа хүн оргодол цогцос, мал, эд зүйлийг илрүүлэх, олж тогтоох чиглэлээр

Баянзүрх дүүрэг дэх цагдаагын газрын нэгдүгээр хэлтсийн “Эрэн сурвалжлах ажил хариуцсан орон тооны бус ажлын хэсэг”-ийг дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга ахлаж 14 хоног тутам хуралдаж эрэн сурвалжлах ажил, АСАП сангийн ашиглалт, гарч байгаа алдаа зөрчлийг засварлах, анхаарах асуудлын талаар хэлэлцэж, алба хаагч нарын гар дээр шалгагдаж байгаа хэрэгт оргон зайлсан этгээдүүдийг эрэн сурвалжлах чиглэлээр ямар ажил хийж гүйцэтгэснийг нэгдсэн журмаар эрэн сурвалжлах орон тооны бус зөвлөлийн гишүүд шалган зааварчилж ажилласан.

Хэлтсийн дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн даргаас Мөрдөн байцаах, Хэрэг бүртгэх, Нийтийн хэв журам хамгаалах тасгуудад “АСАП” сангийн ашиглалтыг сайжруулах, эрэн сурвалжлах этгээдийн мэдээлэл оруулахдаа анхаарах зүйл, гарч байгаа алдаа дутагдал, санд оруулсан эрэн сурвалжлалтуудыг тулгалт хийх чиглэлээр 2019 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр №10 дугаартай 11-13 төрлийн ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэх зааварчилгааг өгч, үүний дагуу хийсэн ажлын үр дүнгийн талаар илтгэх хуудсаар хариуг авч, тасгуудаас санд оруулсан эрэн сурвалжлалтуудыг тулгалт хийлгэн, хэрэг нь илэрсэн, шийдвэрлэгдсэн эрэн сурвалжлалтуудыг зогсоолгох чиглэлээр хяналт тавьж ажилласан.

Эрэн сурвалжлах “ASAP” санд программын алдаанаас болж эрэн сурвалжлалт зарлах 2, эрэн сурвалжлалт зогсоох 3, алга болсон хүн эрэн сурвалжлах 34 /2018 оны/, оргодол эрэн сурвалжлах 1 хянагдсан төлөвт авагдсан боловч алдаа зааж байсныг Мэдээлэл технологийн төвд хандан засуулах арга хэмжээ авч бүртгэж ажиллав. Одоогийн байдлаар АСАП санд бүргэгдээгүй, хянагдсан төлөвт ямар нэг мэдээлэл байхгүй зөрчилгүй.

Тус цагдаагийн хэлтэст 2019 оны эхний 12 сарын 15-ний өдрийн байдлаар сураггүй алга болсон хүн 32, шүүхээс даалгасан бусад хүн 166, оргодол 3, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 42, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 115, тээврийн хэрэгсэл 16, галт зэвсэг 8, мал амьтан 0, аман зургаар 30, эд зүйлс 3481 эрэн сурвалжлагдаж байгаа бөгөөд АСАП сангийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр 4 удаа бичгээр зааварчилгаа боловсруулан өгч, тулгалтыг хийлгэж, сангийн зөрчлийг арилгуулсан.

Тайлант хугацаанд 2019 оны эхний 12 сарын 15-ны байдлаар сураггүй алга болсон хүн 233, шүүхээс даалгасан хүн 190, оргодол 5, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 192, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 2, галт зэвсэг 0, бодис 1, тээврийн хэрэгсэл 38, мал амьтан 0, эд зүйлс 251 олж тогтоон эрэн сурвалжлалт зогсоосон, эрэн сурвалжлах ажлын гүйцэтгэл **74.8** хувьтай байна.

Мал хулгайлах болон анхаарал татсан зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар

Тус цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Нарантуул ОУХТ, Сандэй худалдааны төв, Их орд худалдааны төв, Баянзүрх, Шинэ Баянзүрх, Миний зах, Генерал, Эко худалдааны төв, Офицер зах, Номин их дэлгүүр, Асио худалдааны төв зэрэг нийт 40 томоохон зах, худалдаа үйлчилгээний төвийн зохион байгуулагч, менежерүүдтэй уулзаж, мэдэгдэл өгч үр дүнг тооцон ажилласан. Махны худалдаа арилжаа хийдэг 18 аж ахуй нэгж, ченж нарыг бүртгэл судалгаанд авч, урьдчилан сэргийлэх чиглэлээр камержуулах талаар албан мэдэгдэл өгч, мэдэгдэлийн хариу, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлыг шалган дүнг тооцсон.

Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, хүн ихээр төвлөрсөн “Нарантуул” ОУХ төв, “Сандэй” төв болон хэлтсийн төв байрны хүээлгийн зааланд “Малчин лавлах-109” дугаарын зурагт хуудас, дэлгэцээр видео шторкыг байрлуулан иргэдэд сурталчилах, үйл ажиллагааг олон нийтэд хүргэж таниулах ажил арга хэмжээг зохион байгуулан, хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг зах, худалдааны төвүүд, автобусны буудлуудад хулгайн гэмт хэрэгт өртөхөөс иргэдийг сэрэмжлүүлсэн зөвлөмж, зурагт хуудас, сэрэмжлүүлэг нааж, зурагт, FM радиогоор энэ төрлийн урьдчилан сэргийлэх ярилцлагыг 2 удаа хийсэн.

Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгө битүүмжлэх, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил

Нууц далд үйлдлээр үйлдэгдсэн хэрэгт 2019 оны эхний 11 сарын байдлаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нийт 534,145,000 төгрөгийн нуугдмал эд хөрөнгө илрүүлж, хохирлыг барагдуулсан.

ТАЙЛАН БИЧСЭН:
ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХМАД Г.БУЙРЦЭНГЭГ

ТАНИЛЦСАН:
ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Б.АРИУНЖАРГАЛ

